

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

**Зөвлөмж 1. Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтныг мэргэшүүлж, тогтвор сууршилтай ажиллуулахад анхаарч, тэднээс эрх, үүргээ хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах**



**Хэрэгжүүлсэн арга хэмжээ:** Авлигатай тэмцэх газарт нийтийн албан томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгийг батлагдсан маягтын дагуу цаасаар болон цахимаар мэдүүлэх бүртгэж архивлах талаар Нийтийн албан тушаалтнуудад болон эрх бүхий албан тушаалтнуудад 4/2118 албан бичгээр 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр чиглэл хүргүүлэн, хяналт тавин ажилласан. Мөн төрийн албан хаагчдад өөртөө үйлчлэх хууль эрх зүйн актуудаа судлах талаар арга зүйн зөвлөгөө өгч хяналт тавин ажилласан.

**Хүрсэн үр дүн:** Эрх бүхий албан тушаалтнуудын албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой зөрчил буурсан.

**Зөвлөмж 2. Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй, нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж бичгээр мэдэгдэх, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар гаргаж хэвшүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах**

**Хэрэгжүүлсэн арга хэмжээ:** Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хязгаарлалт, хориглолт, хариуцлагын талаар зөвлөмжийг сум, байгууллагуудын дарга эрхлэгч нарт 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 4/2112 албан бичгээр хүргүүлэн, хяналт тавин ажилласан. Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалтаар 20 сумын удирдах албан тушаалтнуудад сургалт зохион байгуулж ажилласан.



Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 20 сум, 55



байгууллагын 18550 гаруй иргэд, төрийн албан хаагч, сурагчдад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, захиалгат танхимын сургалтыг зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн "Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалт", Монгол улсын Засгийн газрын 2023 оныг "Авлигын эсрэг жил болгон зарлах тухай" 49

дүгээр тогтоол, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг сэдвүүдээр

сургалтад хамруулж мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэн ажилласан.

**Хүрсэн үр дүн:** Аймгийн 20 сум, 55 байгууллагын 18550 гаруй иргэд, төрийн албан хаагч, сурагчдын авлигын талаарх хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн.

**Зөвлөмж 3. Нийтийн албан тушаалд томилогдсноос хойш хуульд заасан хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргаж хэвшүүлэх, хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож байх, түүнд тавих хяналтыг сайжруулах**

**Хэрэгжүүлсэн арга хэмжээ:** ХАСХОМ мэдүүлэхдээ дараахь зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар чиглэл өгч нийтэд ил тод байдлаар сум, байгууллагуудын цахим хуудсанд харагдах хэлбэрээр аймгийн цахим хуудсанд байршуулан ажилласан.



**Хүрсэн үр дүн:** Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар мэдүүлэг гаргах үүрэгтэй албан тушаалтнууд ХАСХОМ-ыг хуульд заасан хугацааны дотор гаргасан. Хугацаа хоцорч тайлагнасан зөрчил илрээгүй болно.


**Зөвлөмж 4. Нийтийн албан томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүй томилдог, томилсны дараа хянуулдаг зөрчлийг таслан зогсоох**

**Хэрэгжүүлсэн арга хэмжээ:** Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тогтоомжийн




талаар Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран байгууллагын 34 албан хаагчдад 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Номгон телевизтэй хамтран Албан хаагчдыг оролцуулсан **“Үгүй гэж хэлээд өөрчилье, Авлигын эсрэг нэгдье”** уриалгыг дэвшүүлсэн видео шторк бэлтгэн <http://bayankhongor.hudulmur-halamj.gov.mn> вэб сайт, [https://www.facebook.com/БАЯНХОНГОР\\_ХӨДӨЛМӨР\\_ХАЛАМЖ/](https://www.facebook.com/БАЯНХОНГОР_ХӨДӨЛМӨР_ХАЛАМЖ/) пэйж хуудас, номгон телевизээр тус тус түгээж иргэд олон нийтэд сурталчлан ажилласан.




Авлигад өртөж болзошгүй албан хаагчдын судалгаа гарган Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, төрийн албаны нэр хүндийг өргөх, ёс зүйг эрхэмлэж ажиллах талаар байгууллагын албан хаагчидтай “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах гэрээ”-г байгуулан ажилласан.

Албан хаагчдын дунд авлигын хор уршгийг олон нийтэд сурталчилсан богино хэмжээний шторкийн уралдаан зарлаж эхний 3 байр шалгаруулан шагнаж урамшуулан шилдэг шторкуудыг нийтэд сурталчлан ажилласан байна.



Засаг даргын эрхлэх хүрээний төрийн байгууллагуудын дунд **“АВЛИГА үгүй бол ТӨР амгалан, АРХИ үгүй бол ГЭР БҮЛ амгалан”** уриалгыг дэвшүүлэн ДЭВЖЭЭ тэмцээнийг зохион байгуулсан.

Тус тэмцээнд 4 байгууллагын 38 алба хаагчид оролцож







- † Тэргүүн байранд Онцгой байдлын газар шалгаран Өргөмжлөл 300,000 мянган төгрөг,
- † Дэд байранд Байгаль орчин аялал жуулчлалын газар шалгаран Өргөмжлөл 200,000 мянган төгрөг,
- † Гутгаар байранд Эрүүл мэндийн газар шалгаран 100,000 мянган төгрөг,
- † Тусгай байранд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар шалгаран Өргөмжлөл 80,000 мянган төгрөгөөр тус тус шагнагдсан.

“Авлига авч удмын нэрээ сэвтээхгүй” уриалгыг дэвшүүлэн Төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарыг уриалан 8 байгууллагын удирдлагуудыг аянд нэгдүүлж ажилласан



“Авлига үгүй бол төр амгалан, Архи үгүй бол гэр бүл амгалан” уриалгыг төрийн албан хаагчид, иргэдэд дэвшүүлэн уриалж 232 төрийн албан хаагч, 85 иргэн, 36 сурагч тус аянд нэгдэн ажилласан байна.



**Хүрсэн үд дүн:** ХАСУМ-ыг хянуулахгүйгээр томилсон зөрчил гараагүй болно.

**Зөвлөмж 5.** Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа төрийн албан хаагчаас өөрийн болон өөртөө хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр гаргах, хөндлөнгөөс нөлөөлөхөөс зайлсхийх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны II дугаар улирлын байдлаарх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгон батлагдсан төлөвлөгөөнд Олон улсын төслийн санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сан болон

орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 49 нэр төрлийн 10.6 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн.

Энэ оны тайлант хугацаанд 10.6 тэрбум төгрөгийн 49 нэр төрлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зарласан бөгөөд аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны II дугаар улирлын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгосон төлөвлөгөө 85%-ийн биелэлттэй байна. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг Засгийн газрын худалдан авах ажиллагааны “tender.gov.mn” болон Баянхонгор аймгийн “bayankhongor.gov.mn”, umch.bkh.gov.mn сайтуудад байршуулан олон нийтэд сурталчилсан.




Мөн 2023 оны нийт 30 тендерийн урилгыг tender.gov.mn, bayankhongor.gov.mn сайт, umch.bkh.gov.mn, “Зууны мэдээ” сонинд тухай бүр нийтлүүлсэн.

Тухайн тендерт оролцогчийн шалгарсан болон шалгараагүй шалтгаан, үр дүнг Засгийн газрын tender.gov.mn сайтад тогтмол оруулж ажилласан.

Тухайн тендерт оролцогчийн шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсны дараа гэрээг цахим системд оруулна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг жилийн эцсийн байдлаар бүр цаг хугацаанд нь гаргаж Bayankhongor.gov.mn майтад байршуулж ажиллав.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журамд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг жилийн эцсийн байдлаар цаг хугацаанд нь гаргаж Bayankhongor.gov.mn,



umch.bkh.gov.mn сайтад байршуулж ажилласан. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, хяналт шалгалтын дүнг Bayanhongor.gov.mn, umch.bkh.gov.mn сайтад тогтмол байршуулж ажилласан.

Орон нутгийн өмчийн газраас 2023 оны 02 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд Төрийн худалдан авах ажиллагаанд мэргэшүүлэх "АЗ" сертификат олгох сургалтыг "Худалдан авах ажиллагааны сургалт судалгааны төв" ТББ-тай хамтран зохион байгууллаа. Сургалтад аймгийн бүх сумдаас төрийн алба, төрийн бус байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл нийт 116 хүн хамрагдснаас 65% буюу 76 хүн шалгалтанд тэнцэж, шинээр төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сертификат авлаа.

Тендер шалгаруулалт явуулах явцад гарсан аливаа санал гомдлыг шийдвэрлэн ажиллахаас гадна холбогдох байгууллагад шилжүүлж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

Энэ оны хагас жилийн байдлаар 30 үнэлгээний хороо байгуулагдсан 46 шийдвэр гаргасан бөгөөд шийдвэр бүрийг цахим хуудсанд байршуулж, үнэлгээний хорооны бүрэлдэхүүн тус бүрт иргэний төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөллийг байнга оролцуулан ажиллаж урамшуулал олгохоор төлөвлөж байна. худалдан авах ажиллагааны өдөр тутамын ажил болон зарлагдаж байгаа тендерийн мэдээлэл болон сар, улирал, жилийн тайланг тухай бүр иргэд болон аж ахуйн нэгжүүдэд мэдээллийг ил тод байлгах үүднээс тухай бүр байгууллагын мэдээллийн самбарт, Bayanhongor.gov.mn, umch.bkh.gov.mn сайтуудад байршуулан ажиллаж байна.

**Зөвлөмж 6.Засаг даргын нөөц хөрөнгийн захиран зарцуулалтыг үр ашигтай байлгах, зөвхөн хууль, журамд заасан үндэслэлээр зарцуулах, түүнд хяналт тавих хяналтыг сайжруулах, зарцуулалтын тайланг ил тод байлгахад анхаарах**

**Хэрэгжүүлсэн арга хэмжээ:** Аймгийн засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс дарга, мэргэжилтнүүдэд Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалаар "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг танилцуулж цаашид нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах сургалт хийж чиглэл өгч ажилласан. Журмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор сумдын засаг дарга нарын захирамжийн төслүүдэд тогтмол хяналт тавьж зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажилласан. Мөн Засаг даргын нөөц хөрөнгөтэй холбоотой захирамжуудын эрх зүйн үндэслэлийг төслөөр танилцуулах хугацаанд <https://eoffice.bayanhongor.gov.mn/> цахим программаар удирдлагуудад хянуулсны дараа албажуулан ажилласан. Аймгийн ЗДТГ нь 2023 он 775.981.000 төгрөгийн төсөв баталж 775.976.908 нөөц хөрөнгийг журмын хүрээнд зарцуулан ажилласан.

Хүрсэн үр дүн:Батлагдсан төсвийг журмын хүрээнд зарцуулсан.

**Зөвлөмж 7.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хандив авахтай холбоотой хязгаарлалтыг чанд мөрдөж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх , хууль зөрчиж хандив авч буй үйлдлийг нэг мөр таслан зогсоох, хандивлагчтай холбоотой шийдвэр гаргахгүй байх.**

*Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах ажлын хүрээнд:*

Аймгийн гэмт хэргэг, зөрчлөөс урьдчилан ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн хэлтэс Прокурорын газартай

хамтран аймгийн хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Тус зөвлөгөөнөөр Авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авч, авлигын эсрэг сургалт,



сурталчилгаа зохион байгуулах талаар Тус зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжид тусган хэрэгжилтийг ханган ажилласан.

Аймгийн прокурорын газраас “Авлигын гэмт хэргийн мэдээлэл, түүний түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдвээр төрийн байгууллагуудын удирдах 30 албан тушаалтанд сургалт, мэдээлэл хийж “Авлигын гэмт хэрэг, түүнээс урьдчилан



сэргийлэхэд удирдах албан тушаалтны манлайлал чухал үүрэгтэй” сэдвээр сургалт зохион байгуулав.



-Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах зорилгоор 2023 оны 02 дугаар сараас эхлэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай "Нэг цонх"-ны үйлчилгээний төвөөр үйлчлүүлж буй иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэн дүгнэлт хийсэн.

-Баянхонгор Аймгийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс сургагч багшийн зардлыг шийдвэрлүүлэн орон нутагтаа 6 сургагч багш шинээр бэлтгэхээр Авлигатай тэмцэх газарт санал өгч сургалтад хамруулан сургагч багшаар бэлтгэсэн болно.



Тус сургалтад хамрагдсан сургагч багш нар сумдын хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын мэргэжилтнүүд, засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын мэргэжилтнүүдийн төлөөллөөс бүрдсэн 55 эрх зүйн хөтчийг тухайн сум байгууллагадаа авлигын эсрэг сургалт сурталчилгаа зохион байгуулах сургагч багшаар бэлтгэн гэрчилгээжүүлсэн.

Сургалтад оролцсон нийт эрх зүйн хөтөч нарын албан хэрэгцээнд 2023 онд шинэчлэн найруулагдсан болон шинээр батлагдсан хуулиудын эмхэтгэл гарын авлага мөн аймгийн цахим хуудасны ил тод байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хялбаршуулсан гарын авлагыг авлагаар хангаж ажилласан.

Сургалтын үеэр эрх зүйн хөтөч нартаа "Авлигын эсрэг нэгдье", "Эрх зүйн



боловсролыг иргэн бүрд" гэсэн уриалга бүхий түлхүүрийн оосор, альбом, сургалтын персентацыг плаш хэлбэрээр олшруулан тарааж сургалтын үр дүнгээ дүгнэн ажилласан.



**Зөвлөмж 8.Барилга хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд орж буй албан тушаалтнуудыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, барилга барих, эхлүүлэх, комисс хүлээн авах ажлыг барилгын норм, дүрмийн шаардлагад нийцүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах**

**Барилга хүлээн авах хяналтыг тогтолцоог сайжруулан ажиллах чиглэлээр:**

Аймгийн хэмжээнд 2023 он Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 25, орон нутгийн хөрөнгө оруулалтын 20, хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 35 нийт 80 барилга, байгууламж болон шугам сүлжээ, их засварын ажлуудад захиалагчийн техникийн хяналт тавьж тухай бүрд зураг төсөв болон холбогдох норм дүрэмд заасан шаардлагын дагуу барилга угсралтын ажлын явцыг шалгаж үүрэг даалгавар өгч гарсан зөрчлүүдийг арилгуулан өмнө өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргуулан холбогдох тайлан, судалгаа, мэдээллийг гарган хүргүүлсэн.

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДЭЖ БАЙГАА  
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ЖАГСААЛТААР ХАРУУЛБАЛ**

№	Байршил	Төсөл хөтөлбөрийн нэр
1	Баянхонгор сум	Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн өргөтгөлийн барилга.
2	Баянхонгор сум Шаргалжуут 8-р баг	240 хүүхдийн Сургуулийн барилга.
3	Хүрээмарал сум	Эрүүл мэндийн төвийн барилга
4	Баянбулаг сум	75 хүүхдийн Сургуулийн дотуур байрны барилга
5	Баянцагаан сум	320 хүүхдийн Сургуулийн барилга
6	Богд сум	150 хүүхдийн Сургуулийн дотуур байрны барилга
7	Гурванбулаг сум	160 хүүхдийн Сургуулийн барилга
8	Заг сум	160 хүүхдийн Сургуулийн барилга
9	Эрдэнэцогт сум	15 ортой Сумын эрүүл мэндийн төвийн барилга
10	Шинэжинст сум	Спорт заалны барилга
11	Баянхонгор сум	Мах ногооны зоорь
12	Өлзийт сум	Соёлын төвийн барилга
13	Баянхонгор сум	Баянхонгор сум, Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ
14	Баянхонгор сум	Баянхонгор сум гэр хорооллын Цэвэр, бохир усны шугам сүлжээ
15	Баацагаан сум	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр
16	Эрдэнэцогт сум	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр
17	Галуут	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр
18	Баацагаан сум	Засаг даргын тамгын газрын барилга
19	Богд сум	Цагдаагийн кабоны барилга
20	Жаргалант сум	Цагдаагийн кабоны барилга
21	Баянхонгор сум	150 хүүхдийн 2-р Цэцэрлэгийн барилга
22	Өлзийт сум	Газар тариалангийн кластер төслийн Цогцолбор / Ажилчдын байр, агуулах, тэжээлийн үйлдвэр, тогооны барилга, авто граш
23	Баянхонгор сум	ХАА кластерийн үйлдвэр байгуулах төсөл, ногоон шим төслийн ажил /Өвлийн хүлэмж барилга /
24	Өлзийт сум	Газар тариалангийн кластер төслийн Цогцолбор / Хүлэмж барилга /
25	Эрдэнэцогт, Өлзийт, Баянлиг, Баянцагаан, Хүрээмарал, Гурванбулаг сумдад	Үүрэн холбооны сүлжээ Баянхонгор аймгийн 6 сумын төсөл

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 7, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 17, хувийн хөрөнгө оруулалтаар 7 барилга нийт 31 барилга байгууламжийн ажилд Барилга, байгууламжийг ашиглалт оруулах комисс ажиллан гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн гаргуулж холбогдох тайлан, барилга угсралтын ажлын техникийн бичиг баримтыг авч байнгын ашиглалтад хүлээн авсан.

***Гэр хорооллыг дахин төлөвлөлтөд хамруулан барилгажуулах чиглэлээр:***

Баянхонгор сумын Номгон 1-р багт 2 байршилд Гэр хорооллын газрыг дахин төлөвлөлтөд оруулж гүйцэтгэгчээр “Зоригтболд” ХХК болон “Хээр унага” ХХК-иуд уг ажлыг эхлүүлж “Зоригтболд” ХХК нь 56 айлын орон сууц барилга, “Хээр унага” ХХК нь 40 айлын орон сууцны барилга буюу нийт 96 айлын 2 орон сууцны барилга угсралтын ажлыг гүйцэтгэж тайлант онд 100% дуусган байнгын ашиглалтад оруулсан.



“Зоригтболд” ХХК –ний  
56 айлын орон сууцны барилга  
барилга



“Хээр унага” ХХК-ний 40  
айлын орон сууцны

***Гэгээн шавь 6-р багийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх 1900 айлын гэр хорооллын дахин төлөвлөлт:***

Гэгээн шавь 6-р багийн 13.4 га талбайд 143 айлын газрыг чөлөөлж :

- 1900 айлын 41 блок орон сууцны төлөвлөлт,
- 640 хүүхдийн сургууль,
- 240 хүүхдийн цэцэрлэгтэй байхаар төлөвлөсөн.

Төслийн 1-р ээлжинд:


- Зоорьтой 5 давхар 40 айлын орон сууц-10,
- Зоорьтой ил авто машины зогсоол-150,

- далд зогсоол-100 тус тус төлөвлөсөн бөгөөд төсөл хэрэгжүүлэгчээр “Нью бест хаус” ХХК шалгарч зураг төсөл боловсруулалтын ажил хийгдэж байна

**Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган дахин барилгажуулах чиглэлээр:**

Баянхонгор хотын төвд 1960-1970 оны хооронд баригдсан ашиглалтын шаардлага хангахгүй талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргасан нийтийн орон сууцны барилгуудыг жил бүр үе шаттайгаар дахин төлөвлөлтөд хамруулж байна.

Энэ онд 1,2,7,8,9,10-р байруудыг дахин төлөвлөлтөд хамруулан буулгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлж Баянхонгор сумын Номгон 1-р багт байрлах 36 айлын нийтийн орон сууцны 10-р байрыг дахин төлөвлөлтөд хамруулахаар орон нутгийн төсвөөс 540 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Барилга угсралтын ажлын




гүйцэтгэгчээр “Зүүн шанд” ХХК шалгарч 10 давхар 125 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг 100% гүйцэтгэн 2023 оны 7-р сард ашиглалтад оруулсан.

Нийтийн орон сууцны 2,7,8,9-р байрыг 2022 онд буулган, 2022 онд 6 блок, 7 давхар, 252 айлын орон сууцны барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Хаш гоёо” ХХК шалгарч нэгдсэн хотхон байдлаар төлөвлөгдөн тус орон сууцны хотхоны эхний 1,2 дугаар ээлжийн 98 айлын орон сууцны барилгыг 2023 оны 08 сард, 3,4 дүгээр



ээлжийн орон сууцны барилгыг 2023 оны 12 сард улсын комисс ажиллан, байнгын ашиглалтад оруулсан.



Дахин төлөвлөлтөд хамруулан буулгасан 2,7,8,9-р байр 1-р байрны 18 айлын орон сууцны барилгын гүйцэтгэгчээр “Би ай эм би” ХХК шалгарсан бөгөөд 7 давхар 49 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг 100% гүйцэтгэн улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан.



Нийтийн орон сууцны 1-р байрыг дахин төлөвлөлтөд хамруулан буулгаж, 7 давхар, 49 айлын орон сууцны барилга ашиглалтад оруулсан.

**Зөвлөмж 9. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг, үр ашиг, үйл ажиллагааны давхардал зэргийг сайтар судлах, хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах**

Байшинтын таг ОНӨААТҮГ, Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээ ОНӨҮГ, Жаргалтай амьдрал, сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2020, 2021 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт аудитын алба хяналт шалгалт хийсэн. Шинэжинст сумын удирдах албан тушаалтнууд нь Орон нутгийн өмчит байгууллага байгуулахдаа хууль тогтоомжид нийцсэн шийдвэрийг гаргаж ажиллах. Төрийн аудит, Санхүүгийн хяналт, аудитын албанаас зөвлөмж хүргүүлснээр



Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний газрыг 2022 оны 09 дүгээр сарын 01-нээр тасалбар болгон татан буулгасан.

Байшинтын таг” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэргүйгээр бүтэц орон тоог нэмэгдүүлж төсвийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”. 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн тул татан буугдсан. Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Жаргалтай амьдрал” сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн ажил, албан тушаалын жагсаалт, цалин тогтоолыг батлах тухай” Б/01 дүгээр тушаалын 1-т “Жаргалтай амьдрал” сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн ажилтан албан хаагчдын албан тушаал, орон тоо нэгдүгээр хавсралтаар, олгох цалинг хоёрдугаар хавсралтаар баталсугай” гэж заасан атлаа хавсралт гаргаагүй ямар орон тоогоор хэдэн хүнд цалин хөлс олгох нь тодорхойгүй, мөн хоолны мөнгө олгохоор шийдвэр гаргаагүй атлаа хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна. Цаашид орон нутгийн болон төрийн өмчид хуулийн этгээдийн үр ашиг үйл ажиллагааны дархардлыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар оруулж шийдвэрлүүлэн ажиллаж байна.

ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ БИЧСЭН  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН  Ж.ЛХАМДУЛАМ